



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/582

Хэрлэн сум

“Талын түмэн адуу -2023” эвент
арга хэмжээнд хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Аялал жуулчлалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1, 23.1.9 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны хорьдугаар хуралдааны “Аймгийн 2023 оны төсвийн тодотгол батлах тухай” 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу өвөл цагийн эвент арга хэмжээг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбарын хөгжлийг эрчимжүүлэх, төр хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах, аймаг орон нутгаа сурталчлах, нутгийн ахуй соёл, зан зашлыг олон улсын хэмжээнд таниулах зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Талын түмэн адуу-2023” эвент арга хэмжээг зохион байгуулахад 10,000,000 (арван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.


2.Зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023
оны 11 дугаар сарын 17-ны
дугаар захирамжийн хавсралт

**“ТАЛЫН ТҮМЭН АДУУ-2023” ЭВЕНТ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Зохион байгуулах арга хэмжээ	Зардал / сая төгрөг/	Тайлбар	Дэмжигч байгууллага
1	Удамт Монгол хүүхдийн морьтон парад	1.680.000	Нээлтийн үзүүлбэр	Хэнтий аймгийн ЗДТГ
2	Сайхан Хос морьтон	3.000.000	I байр 1,000,000 II байр 800,000 III байр 600,000 IV байр 400,000 V байр 200,000	Хэнтий аймгийн ЗДТГ
3	Эмнэг булгиа шалгаруулах тэмцээний шагнал	1.000.000	I байр 500,000 II байр 300,000 III байр 200,000	Хэнтий аймгийн ЗДТГ
4	Тайга нохой, анч бүргэдийн үзүүлбэр	3.000.000	Нээлт, хаалтын үзүүлбэр	Хэнтий аймгийн ЗДТГ
5	Сээр цохих тэмцээний шагнал	1.000.000	I байр 500,000 II байр 300,000 III байр 200,000	Хэнтий аймгийн ЗДТГ
6	Цахилган үүсгүүр генераторын түлш	320.000	80 л дизель түлш * 4,000	Хэнтий аймгийн ЗДТГ
	НИЙТ ДҮН		10.000.000	